



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/235

Мандалговь

Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд талбай цэвэрлэгч автомашин нийлүүлэх /Сайнцагаан сум/ ажлыг хүлээлцэх комисс томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 4.3.4 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд талбай цэвэрлэгч автомашин нийлүүлэх” ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Л.Баярсайхан (Хууль эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Д.Очбадрах (Хот тохижуулах газрын дарга)

Гишүүд: Д.Мөнхцоож (Хот тохижуулах газрын ахлах мэргэжилтэн)

Ж.Базарсад (Хот тохижуулах газрын хог хариуцсан инженер)

Э.Эрдэнэбаатар (“Баян-Өндөр” ХХК-ний захирал)

2. Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд талбай цэвэрлэгч автомашин нийлүүлэх ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Л.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

488211160